

**БОЭТ-ИЙН 2019 ОНЫ КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ, БИЕЛЭЛТ**

Д/Д	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран ажиллах байгууллага	Биелэлт
1	“Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх” өдрийг тэмдэглэх	2019 оны 01 дүгээр сар	Гэмтэл, ЧХХ тасаг	Гэмтэл, ЧХХ тасаг, нийгмийн ажилтан	Зам тээврийн осол гэмтлээс болон ахуйн гэмтлээс сэргийлэх чиглэлээр 1-р сарын 31 нд осол гэмтлийн өдөр төлөвлөгөө гарган ажилласан үүнд : Осол гэмтлийн талаар тасгийн эрхлэгч их эмч Д.Цэрэнбадам ховд тв-д ярилцлага өгсөн, мөн түлэгдэл өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тасагт хэвтэн эмчлүүлэгчдэд мэдээ мэдээлэл хийж БОЭТ –ийн эмч нарт ослын үе анхны үеийн тусламжийг зөв үзүүлдэг арга барилд сургах сургалт хийсэн. Мөн нийгмийн ажилтантай хамтран замын цагдаагын болон хот тохижуулалтын ажилтдад халуун аарц цайгаар дайлан 1 өдрийн ажилтай нь танилцаж хамтарч, БОЭТ –өөр үйлчлүүлж буй ард иргэдэд сургалт явуулж боршур тараасан
2	Сар шинийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх	2019 оны 02 дугаар сар	Хүний нөөц, Нийгмийн ажилтан	Захиргааны тасаг	Сар шинийн баярыг тохиолдуулан БОЭТ-өөс өндөр настаны тэтгэвэрт гарсан-150 гаруй ахмад настанд хүндэтгэл үзүүллээ. Мөн байгууллага хамт олны золголтын үйл ажиллагаа зохион байгуулж ажиллаа. Мөн сар шинийн баяраар байгууллага дээр гарах хариуцлагатай жижүүрийг захирлын тушаалаар томилож ажиллууллаа.
3	Сонсгол хамгаалах ОУ-ын өдөр	2019 оны 02 дугаар сар	Гэмтэл, ЧХХ тасаг	Гэмтэл, ЧХХ тасаг, нийгмийн ажилтан	Манай Ховд аймгийн БОЭТ –ийн Чих хамар хоолойн тасаг “ Сонсгол хамгаалах “ олон улсын өдрийг тохиолдуулан “Сонсголоо хамгаалаа “ уриан дор дараах ажлуудыг төлөвлөгөө гарган хийж биелэлт үр дүнг тооцож ажиллалаа  Ховд аймгийн хүн амын дунд сонсголын бэрхшээлтэй иргэд болон хагалгаанд орсон үйчлүүлэгчдийн судалгаа гаргасан. Сонсгол хамгаалах өдрийг тохиолдуулан дунд сургуулийн 12- жилийн дунд сургуулийн 6-р ангийн нийт 150 хүүхдэд үзлэг оношилгоо хийлээ. Мөн ахмад настны “ Цагаан-Уул” сувилалд 55 ахмадуудын сонсголыг шалгаж зөвлөгөө өгч ажиллалаа  Ард иргэд албан байгууллагуудад сонс“Сонсголоо хэрхэн хамгаалах талаар хичээл заасан нь үр дүнтэй боллоо.

					<p>Мөн хэвлэл мэдээлэлийн байгууллагатай хамт хамтран чих хамар хоолойн эмчийнзөвлөгөөг цуврал болгон</p> <p>Ховдын мэдээ сонинд нийтлүүлсэн ба их эмч Ж..Цолмон</p> <p>"Олон ястны" телевизд чих хамар өвчлөлийн талаар мэдээ мэдээлэл хийж ярилцлага өгсөн</p>
4	Дэлхийн эмч нарын баярыг тэмдэглэн өнгөрүүлэх	2019 оны 03 дугаар сар	Хүний нөөц, Нийгмийн ажилтан	Захиргааны тасаг	<p>Олон улсын эмч нарын өдөр гэхээсээ илүү дэлхийн нийтээр эмч нартаа талархдаг баяр гэж ойлгож болно.</p> <p>Анх энэ өдрийг 1933 оны 3-р сарын 30-ны өдөр Америкийн нэгдсэн улсад тэмдэглэж эхэлсэн түүхтэй бөгөөд тус улс 1990 оны 3-р сарын 30-ны өдрийг "Үндэсний эмч нарын өдөр" болгон тэмдэглэх болсноос хойш Дэлхийн эмч нарын холбооноос энэ өдрийг жил бүр албан ёсоор тэмдэглэж ирсэн. Америкийн нэгдсэн улсын эмч нар анх санаачилж байсан бол өдгөө дэлхий нийтээрээ эмч нартаа баярлаж талархсанаа илэрхийлдэг олон улсын өдөр болон өргөжөөд байгаа юм.</p> <p>Энэхүү өдрийг угтан БОЭТ нийт эмч нарынхаа дунд гар бөмбөгийн тэмцээн 2019 оны 03-р сарын 27-ны өдөр амжилттай зохион байгуулж 03-р сарын 29-ны өдөр эмч нартаа хүндэтгэл үзүүлэх ёслолын ажиллагааг зохион байгууллаа.</p> <p>Эмч нарын баярын нээлтийн үйл ажиллагаанд:</p> <p>Ховд аймгийн Засаг дарга Б.Дүгэржав, аймгийн ИТХ-ын Нутгийн Удирдлага, бодлого зохицуулалтын хэлтсийн дарга Ш.Батсүх, ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Даваадорж, Эрүүл мэндийн газрын дарга Ц. Мягмарсүрэн, БОЭТ-ийн захирал Т.Баяртогтох болон аймгийнхаа эрүүл мэндийн салбарт ажиллаж буй эмч нар, ахмад эмч нарын төлөөлөл оролцов.</p> <p>БОЭТ-ийн захирал хүн амынхаа эрүүл мэндийг сахин хамгаалах үйлсийн төлөө амь биеэ үл хайрлан тэмцэж яваа үе үеийн эмч нартаа "Дэлхийн эмч нарын өдөр"-ийн мэнд хүргээд цаашдынх нь ажилд нь амжилт, амьдралд нь сайн сайхан бүхнийг хүсэн ерөөлөө.</p> <p>БОЭТ-ийн захиргаанаас нийт эмч нартаа гарын бэлэг гардуулж</p>

					<p>энэ үеэр шагналын хур бууж эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх, хүн ардынхаа эрүүл мэндийг сахин хамгаалах үйлст үр бүтээлтэй ажиллаж буй эмч нарыг шагнаж урамшуулав.</p> <p>Ховд аймгийн засаг даргын жуух бичиг- 2 их эмч</p> <p>Ховд аймгийн засаг даргын хүндэт өргөмжлөл- 3 их эмч</p> <p>Ховд аймгийн ИТХ-ын хүндэт өргөмжлөл- 3 их эмч</p> <p>Жаргалант сумын хүндэт өргөмжлөл-5 их эмч</p> <p>Монголын залуучуудын холбооны шагнал-5 их эмч</p> <p>Эрүүл мэндийн газрын нэрэмжит шагнал-1 их эмч</p> <p>БОЭТ-ийн захирлын нэрэмжит шагнал-2 их эмч</p> <p>Төрийн банкны нэрэмжит шагнал -1 их эмч</p>
5	Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр	2019 оны 3 сар	Сүрьеэгийн тасаг	Нийгмийн ажилтан	<p>ЭМС-ын 2013 оны 448-р тушаалын 6 дугаар хавсралт, 2014 оны 13 дугаар тушаал, 312 дугаар тушаалуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:</p> <p>Жилийн болон Дэлхийн Сүрьеэтэй тэмцэх өдөр 3 сарын 24 өдөрт төлөвлөгөө гаргаж сургалт сурталчилгааны ажлуудыг хийж байна.</p> <p>Сүрьеэгийн диспансер ЭМГ-ын НЭМХ болон сүрьеэ хариуцсан мэргэжилтэнтэй хамтарч аймгийн хэмжээнд сүрьеэ өвчнөөс сэргийлэх сургалт сурталчилгааны жилийн төлөвлөгөө гарган ажиллаж байна.</p> <p>Сургалт сурталчилгааны чиглэлээр:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Дэлхийн Сүрьеэтэй тэмцэх өдөр - 3 сарын 24 өдрийг угтсан төлөвлөгөө гарган БОЭТ-ийн захирлаар батлуулан ажиллав.</li> <li>- ЭМГ-ын даргын иргэдийн дунд зохион байгуулах сургалт сурталчилгааны удирдамжийн дагуу ажиллав.</li> <li>- Орон нутгийн Олон ястны телевизийн “Ярилцах цаг” нэвтрүүлэгт оролцон сүрьеэ өвчний одоогийн байдал, зорилго чиг хандлага, Ховд аймгийн сүрьеэ өвчний одоогийн байдлын талаар мэдээлэл өгөн ярилцлага хийв. /Зураг/</li> </ul>

					<ul style="list-style-type: none"> <li>- Сүрьеэ өвчнөөс сэргийлэх талаарх эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор шторк, сурталчилгааны мэдээлэлийг телевизээр нэвтрүүлэв.</li> <li>- Аймгийн төвийн байгууллагууд болон ӨЭМТ-үүдэд, БОЭТ-ийн амбулаторийн үйлчлүүлэгч нарт сурталчилгаа хийх, сургалт, АХА тэмцээн зохион байгуулах, олон нийтийн хэвлэл мэдээлэлийн байгууллагад хандан мэдээлэл хийх зэрэг ажлуудын хийсэн.</li> <li>- БОЭТ-ийн эмч сувилагч тусгай дунд мэргэжилтнүүд үйлчлэгч нарын дунд АХА тэмцээн зохион байгуулж 60 хүн хамрагдав. Эхний 3 байр эзэлсэн мэргэжилтнүүдийг үнэ бүхий дурсгалын зүйл гардуулж урамшууллаа. ХоИС-ийн 300 оюутануудад ЭМГ-ын мэргэжилтэнтэй хамтарч сүрьеэ өвчний тухай мэдээлэл, сүрьеэ өвчнөөс сэргийлэх чиг хандлагын талаар сургалт хийв. явуулав. Зураг/</li> <li>- Сүрьеэ өвчнөөс сэргийлэх сурталчилгааг ШШГГ-ын хүмүүжигч нар, ЗХ-ны 123-р ангийн бие бүрэлдэхүүнд хийв. Сум өрхийн ЭМТ-үүдтэй гурвалсан гэрээний дагуу хамтран ажиллаж байна. <ul style="list-style-type: none"> <li>- Сүрьеэгийн талаархи тушаал журмыг танилцуулах,</li> <li>- ЭМГ болон Сумдын эмч нарын холбооноос хийсэн хяналтын зөвлөмжийн биелэлт,</li> <li>- Сүрьеэгийн эмчилгээтэй өвчтөний хяналт,</li> <li>- Хавьталын урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байдал үр дүн</li> <li>- Сорьц тээвэрлэлт,</li> <li>- Эрт илрүүлэгийн үзлэг зохион байгуулах</li> </ul> </li> </ul> <p>Урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны чиглэлээр хяналт үнэлгээг Зэрэг, Манхан, Дуут, Эрдэнбүрэн, Мөнххайрхан, Манхан сумдаар хийж мэргэжил аргазүйн зөвлөмж өгөв.</p>
6	Давсны хэрэглээг бууруулах дэлхийн өдөр	2019 оны 3 сар	Дотрын тасаг	Нийгмийн ажилтан	<p>Монгол Улсын хүн амын дундах нас баралтын 77 хувийг халдварт бус өвчин эзэлж байгаа нь дэлхийн хүн амын яг ийм шалтгаант нас баралтаас зургаа дахин өндөр тоо юм байна. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн судалгаагаар 15-64 насны гурван хүн тутмын нэг нь 70 нас хүрэхээсээ өмнө зүрх судасны өвчин, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчин</p>

					<p>болон хорт хавдрын аль нэгээс шалтгаалан нас барах эрсдэлтэй байна</p> <p>Давс ба эрүүл мэнд” дэлхийн хөдөлгөөний санаачлагаар улс орнууд “Давсны мэдээлэл сурталчилгааны долоо хоног”-ийг жил бүр гуравдугаар сард тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлал тогтсон. 2019 онд хоолны давс, ялангуяа хүүхдэд өгч буй хоол хүнсний давсыг багасгах, улмаар давсыг хоолны цэснээс хасах асуудалд дэлхий нийт анхаарлаа хандуулж байна. Давсны хэрэглээг багасгах хөдөлгөөнд Монгол Улс 2012 онд нэгдсэн юм. Ингээд ЭМЯ, НЭМҮТ, ХХААХҮЯ, БСУШСЯ, МХЕГ хамтран “Давсыг хоолны цэснээс хасъя” уриаг дэвшүүлж, давсны хэрэглээг багасгах долоо хоногийн аяныг эхлүүлсэнтэй холбоотой ховд аймгийн ард иргэд,албан байгуулага, хувийн хэвшлийн байгууллагуудад мэдээ мэдээлэл хүргэх зорилгоор цахим хуудас болон хэвлэл мэдээллээр мэдээ мэдээлэл, 3 төрлийн шторк цацсан байна.</p>
7	Олон улсын сувилагчдийн өдөр	2019 оны 03 дүгээр сар	Сувилахуйн алба Нийгмийн ажилтан	Захиргааны тасаг,нийгмийн ажилтан	<p>Олон улсын сувилагчдын өдрийг манай улсын хувьд 1995 оноос хойш тэмдэглэж иржээ.</p> <p>Жил бүрийн сувилагчдын өдрийн хүрээнд тэдний мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх, сурталчлах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих зэрэг өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулж тэмдэглэдэг.</p> <p>Ховд аймгийн боэт-ийн сувилагчтусгай мэргэжилтний дунд зохион байгуулсан “сувилагчид бид манлайлалын дуу хоолой”</p> <p>Сэдэвтэжилмэргэжлийн уралдаан,шалгаруулалт амжилттай зохион байгуулагдлаа.нийт тусгай мэргэжилтэн оролцож оролцсон багуудаас</p> <p>1-р байр Сонор баг</p> <p>2-р байр ME&amp;SU баг</p> <p>3-р байр Зөв үйлстэн баг</p> <p>Тусгай байр Smile баг тус тус эзэллээ</p>
8	“Авто ослоор алаг үрсээ	2019 оны 04-дүгээр	Нийгмийн	Нийгмийн ажилтан	<p>БОЭТ-ийн Эмч, эмнэлгийн ажилчид 2019.04.11-ний өдөр 12.30-13.00 цагийн хооронд ойролцоох авто замын дагуу осол, гэмтлийн</p>

	алдсаар байх уу аян”	сар	ажилтан		<p>эсрэг уриалга, анхааруулга тэмдэг бүхий лоозон барьж, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэхэд нэгдэж АВТО ОСЛООР АЛАГ ҮРСЭЭ АЛДСААР БАЙХ УУ!!! АЯНД ОРОЛЦЛОО.</p> <p>“ХАЙХРАМЖГҮЙ, ХАРИУЦЛАГАГҮЙ БАЙДЛАА ОРХИГДУУЛЪЯ - АЛАГ ҮРСЭЭ ХАМГААЛЪЯ” уриан дор зохион байгуулагдаж буй өдөрлөгт нэгдэж үйл ажиллагаанд оролцож байна.</p> <p>Орон даяар Эрүүл мэндийн салбарынхан хамтран # Зам Тээврийн Ослоос Урьдчилан Сэргийлэхийг уриалж байна</p>
9	“Цусны даралт ихсэлтийн аян 2019 “	2019 оны 06 дугаар сар	Дотрын тасаг	Нийгмийн ажилтан Захиргааны тасаг	<p>“ЦУСНЫ ДАРАЛТ ИХСЭЛТИЙН ЭСРЭГ АЯН”</p> <p>“Цусны даралт ихсэх өвчний эсрэг аян” боллоо. Аяны нээлтийг Ард-Аюушийн талбайд зохион байгуулж, Улсын гуравдугаар төв эмнэлэгийн нарийн мэргэжлийн эмч нар, НЭМҮТ-ийн статистикч болон хоол зүйч эмч нар, аймгийн БОЭТ-ийн эмч мэргэжилтнүүд цусны даралт ихсэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг үнэлэх үзлэг, оношлогоог үнэ төлбөргүй хийж, иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч хамтран ажиллаа. Аяны хүрээнд төрийн болон хувийн хэвшлийн албан байгууллагууд, мөн ард иргэд үйлчлүүлж нийт 2000 хүнд зөвөлгөө өгч үйлчиллээ.</p> <p>Ховд аймгийн хувьд зүрх судасны тогтолцооны өвчлөл, тэр дундаа цусны даралт ихсэх, зүрхний шигдээсийн өвчлөлөөр улсын дунджаас өндөр үзүүлэлттэй байгаа нь аяныг хэрэгжүүлэх нэг зорилтот шалтгаан болсон. 2018 оны байдлаар ховд аймгийн хэмжээнд өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд амьсгалын тогтолцооны өвчлөл нэгдүгээрт, зүрх судасны тогтолцооны өвчлөл хоёрдугаарт бичигдэж буй юм. Зүрх судасны өвчлөлийн 63,9 хувийг цусны даралт ихсэлт, 16,1 хувийг зүрхний судас бөглөрөлт, 7,3 хувийг тархи судасны өвчин тус тус эзэлж байна.</p> <p>2018 оны Эрүүл мэндийн статистик мэдээллээр Монголын хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаанд амьсгалын зам, хоол</p>

					<p>боловсруулах, зүрх судас, шээс бэлгийн тогтолцооны өвчин болон бусад өвчин ноогдож байна. Цусны даралт өндөр байх нь бусад олон өвчний суурь болдгийг хүмүүс тэр бүр мэддэггүй. Өөрөөр хэлбэл, энэ нь зүрхний дутагдалд орох, тархинд цус харвах, зүрхний шигдээс болох магадлал өндөр ажээ. Түүнчлэн энэ өвчин сүүлийн үед эрс залуужиж, хот суурин газрын төдийгүй орон нутгийн хүн амын дунд хурдтай тархаж буй нь хөдөлгөөний хомсдол, хүн амын дундах таргалалт, зохисгүй хооллолт, амьдралын хэв маяг өөрчлөгдсөн, стресс зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж буй тухай эмч мэргэжилтнүүд хэлж байна.</p>
10	Дэлхийн цусны донорын өдөр	2019 оны 06 дугаар сар	Цусны салбар төв	Нийгмийн ажилтан	<p>Дэлхий даяар жил бүрийн 6-р сарын 14-нд “Дэлхийн Цусны Донорын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлдэг. Энэхүү өдрийн хүрээнд олон нийтийн аюулгүй цус цусан бүтээгдэхүүний талаарх мэдлэг, хандлагыг дээшлүүлэх, сайн дураараа авлагагүйгээр цусаа бэлэглэж, бусдын амь насыг аврах буянтай үйлст нэгдсэн цусны донорууддаа талархах зэрэг олон арга хэмжээ зохион байгууллаа. 2019 онд “Цусаа бэлэглэсэн донор тандаа баярлалаа” уриан дор Мөн энэ үеээр албан байгууллага иргэдийн дунд цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал, донор байхын нэр хүнд алдар, зохистой хэрэглээ сургалтыг эмч эмнэлгийн ажилчид эмч нарын дунд зохион байгуулж 160 гаруй иргэдийг хамрууллаа.</p> <p>БОЭТ-д хэрэглэж буй цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээний 2010-2019 оны судалгаа хийж, цус цусан бүтээгдэхүүний хэрэглээ өндөртэй төрөх тасаг, дотрын тасгуудын эмч нарт цус цусан бүтээгдэхүүнийг эмчилгээнд хэрэглэж буй орчин үеийн хандлага, альтернатив аргыг хослуулан хэрэглэх нь сургалтыг 2 удаа хийсэн. Энэ ажлын хүрээнд шинэ, залуу донор элсүүлэх, хуучин доноруудыг урамшуулах, хадгалах, олон жил хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалахад бодит хувь нэмэр оруулсан донорыг шагнаж урамшууллаа</p>
11	Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх өдөр	2019 оны 08 дугаар сар	Эм зүйн алба	Нийгмийн ажилтан	<p>“АНТИБИОТИКИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭГ ТӨЛӨВШҮҮЛЭХ, ЭМЭНД НЯНГИЙН ТЭСВЭРЖИЛТ ҮҮСЭХЭЭС СЭРГИЙЛЭХ ”</p> <p>Антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх өдөрлөгийн хүрээнд эм зүйн алба нь нийт 10 ажил зохион байгуулахаар төлөвлөн 90% ийн гүйцэтгэлтэй ажилласан. ЭМС-н 2016 оны 12</p>

				<p>сарын 09 ны А/180 тоот тушаалыг үндэслэн, БОЭТ-н захиралын 2016 оны 12 сарын 16 ны А/42 тоот тушаалын дагуу Эм зүйн алба болж өргөжин эм зүйн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор дараах баг болж ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>❖ Менежментийн баг-Эм зүйн албаны дарга, нөөцийн тасгийн эм зүйч</li> <li>❖ Мэргэжлийн баг-Клиник эм зүйч нар</li> <li>❖ Дэмжих баг-Эм найруулагч,үйлчлэгч</li> </ul> <p>2019 оны 03 сарын 22 ны өдөр А/13 тоот тушаалаар “Эм зүйн алба болон тасаг нэгжүүдийн эмийн эмчилгээнд баримтлах журам” баталсан.үүнд:</p> <p>Эм,эмнэлгийн хэрэгсэл,урвалж оношлуурын ханган нийлүүлэх тухай журам,эмийн гаж нөлөөг бүртгэх журам,мансууруулах сэтгэцэд нөлөөт эм хүлээн авах,олгох,хадгалах бүртгэл хөтлөх,тайлан гаргах тухай журам,нянгийн эсрэг эмийн хэрэглээнд мөрдөх журам,эмийн эмчилгээнд хяналт тавих журам,БОЭТ-н эм зүйн албаны эм түгээх журам,Төлбөрийг төр хариуцах эмийг олгох журамуудыг шинэчлэгдсэн тушаал журамд уялдуулан шинэчилсэн.</p> <p>Антибиотик эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлье” уриан дор хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан ЭЭО Даргаар хянуулан БОЭТ-ийн захиралаар баталгаажуулсан.үүний хүрээнд өдөрлөгийн нээлтийг 07 сарын 04 нд БОЭТ ийн зааланд өглөө 7.30 минутанд хийсэн.Өдөрлөгийн нээлтийг ЭЭО Даргаар удирдуулан эм зүйн албаны гишүүд оролцов.нээлтийн үйл ажиллагаанд цахим бүртгэлээр үйлчлүүлж буй иргэд болон эмнэлгийн ажилчидад зориулан Антибиотик эмийн зохистой хэрэглээний талаар гарын авлага бэлтгэн нийт 60 үйлчлүүлэгч нарт тараан Антибиотик эмийг хэрхэн зохистой хэрэглэх бэ? Сэдвээр сургалт зохион байгуулсан.мөн антибиотик эмийн мэдлэг тодорхойлох зорилгоор асуумж авч дүгнэлт хийсэн.</p> <p>Мөн өдөрлөгийн хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>❖ Цахим бүртгэлээр үйлчлүүлсэн нийт 130 иргэд</li> </ul>
--	--	--	--	--

				<ul style="list-style-type: none"> <li>❖ Тасаг нэгжээр хэвтэн эмчлүүлж байгаа үйлчлүүлэгч -110</li> <li>❖ Эмч-55</li> <li>❖ Сувилагч-37</li> <li>❖ Үйлчлэгч,ажилтан-45</li> <li>❖ Khovd news.mn орон нутгийн мэдээллийн цахим хуудсанд мэдээлэл байршуулсан.</li> <li>❖ Олон ястан телевизд видео хичээл болон сайтаас шторк татан авч 7 сарын 16 аас 26 хүртэл мэдээлэл цацсан.мөн олон ястан телевизд зочны цаг нэвтрүүлэгт эм зүйн албаны дарга оролцон Антибиотик эмийн зохистой хэрэглээ гэж юу бэ?сэдвээр ярилцлага хийж иргэд олон нийтэд мэдээлэл хийсэн.</li> </ul> <p>БОЭТ-ийн цахимаар үйлчлүүлэж буй иргэдэд антибиотик эмийн зохистой хэрэглээ,эмийн гаж нөлөөний талаар видео хичээл 14 хоног гаргаж мэдээлэл өгсөн.</p> <p>Эмч,сувилагч,үйлчлэгч ажилтан нарт антибиотик эмийн зохистой хэрэглээ болон тэсвэржилт үүсч буй талаар мэдээлэл өгснөөр анитиотик эмийн мэдлэг сайжирсан.</p> <p>Сургалтын өмнөх асуумжаар нийт эмч, сувилагчаас “Антибиотик эмийн ойлголтын ” талаарх мэдлэг 65,1%, сургалтын дараах асуумжаар 85,5%-тай үнэлэгдлээ.</p> <p>Эмч нарт MNS5376:2016 стандарт, зөрчлийн тухай хуулийн заалт, жорын судалгаа танилцуулснаар эмч нарын жор бичилт сайжирч антибиотик эмийг жорын маягтанд заавал бичдэг болж хандлага өөрчлөгдөж байна.</p> <p>Эмийн сангууд антибиотик эмийг жорын маягтын дагуу заавал олгодог болж байна.ингэснээр ард иргэд эмч нарт хандан шаардлагатай антибиотик хэрэглэх заалтын дагуу хэрэглэх мөн замбраагүй хэрэглээ буурч байна.</p> <p>БОЭТ-өөр үйлчлүүлсэн ард иргэд антибиотик эмийн зохистой хэрэглээний талаар мэдлэгтэй болж хандлага өөрчлөгдсөн</p>
--	--	--	--	---

12	<p>Эрүүл мэндийн салбарын ажилчдын өдөр болон</p> <p>Мэс заслын 90 жилийн ойн баяр</p>	2019 оны 08 дугаар сар	Захиргааны тасаг	Нийгмийн ажилтан	<p>Ховд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн хамт олон Монгол улсын Засгийн газраас баталсан 2019 оны 193 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/295 дугаар тушаалын дагуу 2019 оны 08 дугаар сарын 10-ны өдөр “Эрүүл мэндийн салбарын ажилтны өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлээ.</p> <p>Энэ жилийн “Эрүүл мэндийн салбарын ажилтны өдөр” Мэс заслын алба үүсэж хөгжсөний 90 жилийн ойтой давхар тохиож үе үеийн эмч, сувилагч, эмнэлгийн ажилчид оролцсоноор онцлог боллоо.</p> <p>Мэс заслын алба үүсэж хөгжсөний 90 жилийн ойн арга хэмжээнд Аймгийн засаг даргын орлогч Ч.Уранчимэг, Жаргалант сумын засаг дарга С.Гантөмөр, Эрүүл мэндийн газрын дарга Ц.Мягмарсүрэн, МУ-ын хүний гавьяат эмч Н.Баасанжав, Б.Отгоншар, О.Бямбаа, Ц.Даваахүү, ахмад сувилагч С.Бямбажав, Жавзанпагма нар оролцож, баярын хурлыг БОЭТ-ийн захирал П.Улаанхүү нээж мэндчилгээ дэвшүүллээ. Хүндэтгэлийн концертыг мэс заслын тасгийн хамт олон толилуулж ахмад буурлуудаа хүлээн авлаа.</p> <p>Баярын хүрээнд эмнэлгийн нийт ажилчдын дунд нөхөрсөг 5 төрөлт спортын тэмцээн уралдаан зохиож нийт ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, витамин Д-гийн шинжилгээнд 92 ажилчныг үнэ төлбөргүй хамрууллаа. Мэс заслын тасгийн хамт олон БОЭТ-ийн шилдэг 32 бөхийн барилдааныг зохион байгуулж явууллаа. Гэмтлийн их эмч, сумын заан Н.Берхбол түрүүлж, Мэдрэлийн их эмч сумын заан Я.Ганболд үзүүрлэж, шөвгийн 4-т гэмтлийн их эмч Б.Батбулган, цусны бага эмч сумын начин Ж.Түмэндэмбэрэл нар шалгарлаа.</p> <p>Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Дэм Дэмэндээ” сайн үйлсийн аянг зохион байгуулж үйлчлэгч Ж.Цэцэгмаад 5 ханатай өргөө цагаан гэр, үйлчлэгч Ү.Даариймаад оюутан хүүхдийн сургалтын төлбөрийн 50% хөнгөлөх эрх, Ховд аймгийн ЗДТГазараас Дуут сумын “Нэвт”-ийн амралтанд 3 хоног гэр бүлийн хамт үнэ төлбөргүй амрах эрхийн бичгийг 5 ажилчинд бэлэглэж урьд урьдын эмнэлгийн ажилчдын баярыг</p>

					<p>бодвол ажилчидруугаа чиглэсэн олон арга хэмжээ зохион байгуулснаараа онцлог байлаа.</p> <p>Мөн эмч, эмнэлгийн ажилчдаа олон жил хүн амын эрүүл мэндийг хамгаалах үйлсэд оруулсан хувь нэмрийг үнэлж МУ-ын Засгийн газрын шагнал Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтнаар 9 хүн, Эрүүл мэндийн яамны Жуух бичгээр 16 хүн, БОЭТ-ийн захирлын нэрэмжит шагналаар 4 хүн, Аймгийн болон харилцагч байгууллагуудын шагналаар 26 эмнэлгийн ажилчдыг шагнаж урамшууллаа.</p>
13	Уламжлалт анагаах ухаанаар эрүүл мэндээ хамгаалах өдөрлөг	2019 оны 09 дугаар сар	Уламжлалын тасаг	Нийгмийн ажилтан	<p>2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Ховд аймгийн БОЭТ-ийн Уламжлалт, сэргээн засах эмчилгээний тасгийн хамт олон “Уламжлалт анагаах ухаанаар эрүүл мэндээ хамгаалъя” сэдэвээр иргэд, үйлчлүүлэгчдэд зориулсан эрүүл мэндийн боловсрол олгох өдөрлөг зохион байгууллаа.</p> <p>Энэхүү өдөрлөг нь Монголын улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд “Хүн амыг уламжлалт анагаах ухааны аргаар эрүүл мэндээ хамгаалах, мэдлэг, арга барилтай болгох, мэдээлэл, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх” зорилгын хүрээнд зохион байгуулсан бөгөөд өдөрлөгт 90 гаруй үйлчлүүлэгч оролцож, “Хий шар бадгана өвчний тухай”, “6 амтны тухай”, “Хүний биед улирал хэрхэн нөлөөлөх тухай”, “Хоолны үл зохицол”, “Идээ ундааны хэмжээг зохицуулах” сэдвүүдээр эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохион байгуулж, 300 гаруй ширхэг гарын авлага, зөвлөмж бэлтгэн тарааж танилцууллаа.</p>
14	Эм зүйчдийн баярын өдөр	2019 оны 09 дугаар сар	Эм зүйн алба	Нийгмийн ажилтан	<p>2012 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр “Олон улсын Эм зүйн холбоо” үүсч байгуулагдан жил бүр дэлхийн эм зүйчдийн чуулга уулзалтыг зохион байгуулдаг болсон.</p> <p>2009 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр Турк улсын Стамбул хотноо хуралдсан Дэлхийн эм зүйн холбооны хурлаас энэ өдрийг “Дэлхийн эм зүйчдийн өдөр” болгон албан ёсоор тэмдэглэж байхаар шийдвэрлэсэн байна.</p> <p>Улс орны аюулгүй байдал, оршин тогтохын үндэс, хөгжил дэвшлийн суурь нь хүний эрүүл мэнд байдаг. Манай эм зүйч нар иргэдийн эрүүл мэндийг хамгаалах эрхэм үүргээ гүнээ ухамсарлан, өндөр мэргэжил эзэмшин, дэвшилтэт технологийг нэвтрүүлж,</p>

				<p>чанартай, аюулгүй, хүртээмжтэй эм зүйн тусламж үйлчилгээг үзүүлэхийг зорин ажилласаар ирсэн. Өнөөдөр Монгол Улсын хэмжээнд 50 гаруй эмийн үйлдвэр, 200 гаруй эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага, 1900 орчим эмийн сан, улсын болон хувийн хэвшлийн эмнэлгүүд болон бусад салбарт нийт 2000 гаруй эм зүйч ажиллаж байна.</p> <p>Монгол хүн бүр эрүүл энх, аз жаргалтай байхад ЭМ ЗҮЙЧ нарын өндөр мэдлэг ур чадвар үүрэг хариуцлага хичээл зүтгэл асар их нөлөөтэй юм.</p> <p>Ховд аймагт Эм зүйчдийн баярын өдрийг албан ёсоор 2017 онд анх удаа Эм холбоо, ЭМГ,Эм зүйн алба хамтран баярын нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж "Антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх" өдөрлөг зохион байгуулсан юм.</p> <p>Энэ жил 2019 онд БОЭТ -ийн Эм зүйн алба нь Дэлхийн эм зүйчдийн баярын өдрийг "ЭМ ЗҮЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ-ЧАНАР АЮУЛГҮЙ БАЙДАЛ" сэдвээр зохион байгуулж байгууллагынхаа удирдлага, тасаг нэгж хамт олондоо танилцууллаа.</p>	
15	Байгууллагын аварга шалгаруулах спортын 3 төрөлт тэмцээн	2019 оны 10 дугаар сар	Захиргааны тасаг,103 хүлээн авах	БТСгазар,нийгмийн ажилтан	<p>Байгууллагын аварга шалгаруулах спортын 4 төрөлт тэмцээн 2019 оны 10 дугаар сарын 19-20-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа.</p> <p>Ховд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Байгууллагын аварга шалгаруулах спортын 4 төрөлт тэмцээн 2019 оны 10 дугаар сарын 19-20-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээний эрэгтэй нийлбэр дүнгээр П.Ичинхорлоо ахлагчтай баг, эмэгтэй нийлбэр дүнгээр Г.Отгонцоож ахлагчтай Захиргааны тасгийн баг шалгарч шилжин явах цомын эзэн боллоо. Энэ жилийн тэмцээнд сагсан бөмбөгийн төрөлийг нэмж оруулсан нь мөн эрэгтэй багийн дунд шилжин явах цомтой болсон нь онцлог байлаа. Энэхүү тэмцээний ерөнхий зохион байгуулагчаар Хүлээн авах яаралтай тусламжийн тасаг, Халдвартын тасгийн хамт олон ажиллаа. Тэмцээнд 4 төрлөөр нийт 120 гаруй тамирчин оролцож хурд хүч авхаалж самбаагаа сорин шилдгүүдээ шалгарууллаа.</p> <p>БОЭТ-ийн захирлын тушаалаар шагналт байр эзэлсэн</p>

					<p>тамирчдад цалингийн хувиар шагнаж урамшууллаа.</p> <p>Шатрын эрэгтэй төрөл:</p> <p>1- байр П.Гэрэлсүрэн /П.Ичинхорлоо ахлагчтай баг /</p> <p>2-р байр Ганбүүрэг /Д.Баярсүрэн ахлагчтай баг /</p> <p>3-р байр Б.Батбулган /Гэмтлийн тасгийн баг/</p> <p>Шатрын эмэгтэй төрөл:</p> <p>1-р байр Мандахнаран /ХАЯТ, Халдвартын баг /</p> <p>2-р байр Айгүль /Шинжилгээ, Уламжлалтын баг /</p> <p>3-р байр Отгонхишиг /Дотор, Зүрх судас, Эмгэг судлалын баг /</p> <p>Теннис /Эрэгтэй/:</p> <p>1-р байр Ц.Золбаяр /Мэс заслын тасаг/</p> <p>2-р байр П.Гэрэлсүрэн / П.Ичинхорлоо ахлагчтай баг /</p> <p>3-р байр Чинзориг /Ж.Тэмүүжин ахлагчтай баг/</p> <p>Теннис /Эмэгтэй/:</p> <p>1-р байр Г.Отгонцоож /Захиргааны тасаг /</p> <p>2-р байр Ц.Оюундулам / ХАЯТ, Халдвартын баг /</p> <p>3-р байр Чулуунхүү /Төрөх ,Эмэгтэйчүүдийн тасаг/</p> <p>Сагсан бөмбөг /Эрэгтэй/:</p> <p>1-р байр –Д.Цэрэнбадам ахлагтай /Гэмтлийн тасаг/</p> <p>2-р байр – Б.Ойнбаяр ахлагтай баг</p>
--	--	--	--	--	---

					<p>3-р байр –П.Ичинхорлоо ахлагчтай баг</p> <p>Сагсан бөмбөг /Эмэгтэй /:</p> <p>1-р байр –Г.Отгонцоож ахлагчтай /Захиргааны тасаг/  2-р байр – Д.Гэрлээ ахлагчтай /Мэдрэл, ариутгалын баг /  3-р байр –Ц.Солонго ахлагчтай /Нярай, Дүрс оношилгооны баг /</p> <p>Гар бөмбөг /Эрэгтэй/:</p> <p>1-р байр – П.Ичинхорлоо ахлагчтай баг  2-р байр – Ц.Мандах ахлагчтай баг  3-р байр – Д.Цэрэнбадам ахлагчтай /Гэмтлийн тасаг/</p> <p>Гар бөмбөг /эмэгтэй/:</p> <p>1-р байр – Г.Отгонцоож ахлагчтай Захиргааны тасгийн баг  2-р байр – М.Өлзийхишиг ахлагчтай Дотор, зүрх судас, эмгэг судлалын тасгийн баг  3-р байр – Д.Гэрлээ ахлагчтай Мэдрэл, Ариутгалын тасгийн баг</p>
16	Ахмадуудад зориулсан өдөр	2019оны 10 сарын 01	Захиргааны тасаг  Бүх тасаг нэгж	Захиргааны тасаг  Нийгмийн ажилтан	<p>Жил бүрийн 10 дугаар сарын 1-нийг дэлхийн улс орнууд “Олон Улсын Ахмадын Өдөр” болгон тэмдэглэдэг билээ. Манай улс 1992 оноос хойш энэхүү өдрийг тэмдэглэж эхэлсэн бөгөөд өдгөө 25 дахь жилтэйгээ золгоод байна. Хамгийн анх 1990 онд НҮБ-аас ахмад настнуудаа хүндэтгэх, тэдний үгийг сонсох, баярлуулахын тулд ийнхүү тэмдэглэх шийдвэрийг гаргаж байсан юм. Энэхүү өдрийг тохиолдуулан БОЭТ-ийн хамт олонРояал ресторанд ахмадуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүллээ.</p> <p>БОЭТ-ийн захирал П.Улаанхүү байгууллагынхаа үйл ажиллагааны тайлан танилцуулж ахмадуудынхаа санал хүсэлтийг сонслоо. Мөн</p>

					<p>шагналын хур бууж БОЭТ-ийн захирлын нэрэмжит шагнал-1, “Эрүүлийг хамгаалахыг тэргүүний ажилтан” цол тэмдэгээр-1, Жаргалан сумын Хүндэт өргөмжлөл-1,Ховд аймгийн Ахмадын холбооны шагнал-1 нийт 4 ахмадыг шагнаж урамшууллаа.</p> <p>Ахмадуудыхаа сонорыг мялааж СТА Даваажаргал, Дуучин Өлзийбаяр нар ая дуугаа өргөлөө. Энэ удаагийн үйл ажиллагаанд БОЭТ-ийн захирал болон 24 тасгийн нэрэмжит “АЗТАЙ АХМАД” шалгаруулж, БОЭТөвөөр очер дараалал харгалзахгүйгээр үйлчлүүлэх үнэмлэх ахмад настнууддаа гардуулсан нь онцлог байлаа. Эмчилгээний хоолны тасгийн хамт олон хүндэтгэлийн зоог, шүүсийг хийж ахмадууддаа бэлэг барилаа.</p>
17	Сэтгэцийн өвчинтэй тэмцэх өдөр	2019оны 10дугаар сар	Сэтгэцийн тасаг	Нийгмийн ажилтан	Дэлхийн сэтгэцийн өдрийг угтаж амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх амиа аврах “40 секундын үйлдэл” урианд нэгдэж Өсвөр насны хүүхдүүдийн амиа хорлолт сэдвээр сургуулийн эмч нар нийгмийн ажилтануулап сургалт хийлээ. Мөн Ховд олон ястаны телевизд ярилцлага өнч мэдээ мэдээлэл сэрэмжлүүлэг хийсэн.
18	Гар угаах өдөр	2019оны 10дугаар сар	Халдвар судлаач	Нийгмийн ажилтан	
19	Чихрийн шижингийн эсрэг өдөр	2019оны 11 дүгээр сар	Амбулаторийн тасаг	Нийгмийн ажилтан	
20	ДОХ-той тэмцэх өдөр	2019 оны 12 дугаар сар	Амбулаторийн тасаг	Нийгмийн ажилтан	<p>ХДХВ/ДОХ/БЗДХ-ын кабинет СДЗШ-ний төв нь 2019 онд нийт 16 ажил төлөвлөж төлөвлөгөөний дагуу ажиллаа.Ховд аймгийн нутаг дэвсгэрт оршин буй 17 сум ,баг, өрхийн иргэдэд нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох , мэдээлэл сургалт суртчилгааны ажлыг зохион байгуулж явууллаа. Бидний ажлын үндсэн чиглэл нь ХДХВ/ДОХ/БЗДХ-тай тэмцэх ажлыг эрчимжүүлэх мэдээлэл, сургалт суртчилгааны арга хэлбэрээр дамжуулан олон нийтэд ялангуяа оюутан залуучуудаднөхөн үржихүйн насны хүмүүст хүргэх зорилгоор ажиллаж байна.</p> <p>Аймгийн хэмжээний бүх донорууд, жирэмсэн эмэгтэйчүүдийг үзлэг шинжилгээндхамруулж байгаа бөгөөд ХДХВ/ДОХ, Тэмбүүг илрүүлэх шинжилгээ, болон наацын шинжилгээг тогтмол хийж байна. ХДХВ/ДОХ,БЗДХ-ыг оношлох</p>

					<p>оношлуур эм урвалжаар ханган ажиллаж байна. Зөвлөгөө өгөх кабинетаар үйлчлүүлэгчдэд мэдээлэл өгч, сургалт суртчилгаа хийж гарын авлагаар ханган үйлчиллээ.</p> <p>ХДХВ/ДОХ/БЗДХ/СДЗШ-ний төвөөр үйлчлүүлж буй хүмүүст ХДХВ/БЗДХ-ийн талаар мэдээлэл хүргэх, зөвлөгөө өгөх, сургалт хийх, эрүүл мэндийн боловсрол олгох, суртчилгааны материал болон бэлгэвч тараах ЭМБО үйл ажиллагааг тогтмол явуулдаг бөгөөд, жил бүрийн 12 дугаар сарын 1-ний өдрийг ХДХВ/ДОХ-ын асуудалд анхаарал хандуулах өдөр болгон тэмдэглэдэг бөгөөд “ХДХВ/ДОХ/БЗДХ-ын кабинет болон лаборатори, МУЗН –ийн Ховд дахь салбар хороотой хамтран энэ өдрийг тохиолдуулан БОЭТ-өөр үйлчлүүлж байгаа үйлчлүүлэгчид болон БОЭТ-ийн ажилчдад жил бүр мэдээлэл хүргэж алиллаа.</p>
--	--	--	--	--	--

**ТАЙЛАН ГАРГАСАН**

**НИЙГМИЙН АЖИЛТАН**

**Т.ОЮУНЧИМЭГ**

Эрүүл мэндийн яамнаас “Осол, гэмтлээс сэргийлэх тогтвортой хөгжил-2030” салбар дундын үндэсний чуулганыг угтаж “Авто ослоор алаг үрсээ алдсаар байх уу” сэдэвт өдөрлөгийг улс орон даяар зохион байгуулсан. Энэ хүрээнд Ховд аймгийн Эрүүл мэндийн салбарын эмч, мэргэжилтнүүд “Авто ослоор алаг үрсээ алдсаар байх уу” уриан дор нэгдэж, байгууллагынхаа ойролцоох авто зам болон төв зам дагуу жагсаж, иргэд, хүүхэд багачуудад зориулан осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх уриалга, зөвлөмж, анхааруулга түгээлээ.Тус өдөрлөгт Ховд аймгийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, 5 өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдийн төлөөлөл 180 орчим хүн оролцсон бөгөөд зам тээврийн осол, гэмтлийн эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах, аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэх, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 300 орчим сурталчилгааны материалыг иргэд, жолооч нарт тараан ажилласан байна.

Зам тээврийн осол гэмтлээс болон ахуйн гэмтлээс сэргийлэх чиглэлээр 1-р сарын 31 нд осол гэмтлийн өдөр төлөвлөгөө гарган ажилласан үүнд : Осол гэмтлийн талаар тасгийн эрхлэгч их эмч Д.Цэрэнбадам ховд тв-д ярилцлага өгсөн,мөн түлэгдэл өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тасагт хэвтэн эмчлүүлэгчдэд мэдээ мэдээлэл хийж БОЭТ –ийн эмч нарт ослын үеп анхны үеийн тусламжийг зөв үзүүлдэг арга барилд сургах сургалт хийсэн.Мөн нийгмийн ажилтантай хамтран замын цагдаагын болон хот тохижуулалтын ажилтдад халуун аарц цайгаар дайлан 1 өдрийн ажилтай нь танилцаж хамтарч, БОЭТ – өөр үйлчлүүлж буй ард иргэдэд сургалт явуулж боршур тараасан

Ховд аймгийн хүн амын дунд сонсголын бэрхшээлтэй иргэд болон хагалгаанд орсон үйчлүүлэгчдийн судалгаа гаргасан.Сонсгол хамгаалах өдрийг тохиолдуулан дунд сургуулийн 12- жилийн дунд сургуулийн 6-р ангийн нийт 150 хүүхдэд үзлэг оношилгоо хийлээ.Мөн ахмад настны “ Цагаан-Уул” сувилалд 55 ахмадуудын сонсголыг шалгаж зөвлөгөө өгч ажиллалаа

Ард иргэд албан байгууллагуудад сонс“Сонсголоо хэрхэн хамгаалах талаар хичээл заасан нь үр дүнтэй боллоо.

Мөн хэвлэл мэдээлэлийн байгууллагатай хамт хамтран чих хамар хоолойн эмчийнзөвлөгөөг цуврал болгон

Ховдын мэдээ сонинд нийтлүүлсэн ба их эмч Ж..Цолмон

” Олон ястны” телевизд чих хамар өвчлөлийн талаар мэдээ мэд мэлээлэл хийж ярилцлага өгсөн

Давс ба эрүүл мэнд” дэлхийн хөдөлгөөний санаачлагаар улс орнууд “Давсны мэдээлэл сурталчилгааны долоо хоног”-ийг жил бүр гуравдугаар сард тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлал тогтсон. 2019 онд хоолны давс, ялангуяа хүүхдэд өгч буй хоол хүнсний давсыг багасгах, улмаар давсыг хоолны цэснээс хасах асуудалд дэлхий нийт анхаарлаа хандуулж байна. Давсны хэрэглээг багасгах хөдөлгөөнд Монгол Улс 2012 онд нэгдсэн юм. Ингээд ЭМЯ, НЭМҮТ, ХХААХҮЯ, БСУШСЯ, МХЕГ хамтран “Давсыг хоолны цэснээс хасъя” уриаг дэвшүүлж, давсны хэрэглээг багасгах долоо хоногийн аяныг эхлүүлсэнтэй холбоотой ховд аймгийн ард иргэд,албан байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудад мэдээ мэдээлэл хүргэх зорилгоор цахим хуудас болон хэвлэл мэдээллээр мэдээ мэдээлэл, 3 төрлийн шторк цацсан байна.

“Цусны даралт ихсэх өвчний эсрэг аян” боллоо. Аяны нээлтийг Ард-Аюушийн талбайд зохион байгуулж, Улсын гуравдугаар төв эмнэлэгийн нарийн мэргэжлийн эмч нар, НЭМҮТ-ийн статистикч болон хоол зүйч эмч нар, аймгийн БОЭТ-ийн эмч мэргэжилтнүүд цусны даралт ихсэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг үнэлэх үзлэг, оношлогоог үнэ төлбөргүй хийж, иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч хамтран ажиллаа. Аяны хүрээнд төрийн болон хувийн хэвшлийн албан байгууллагууд, мөн ард иргэд үйлчлүүлж нийт 2000 хүнд зөвөлгөө өгч үйлчиллээ.

Ховд аймгийн хувьд зүрх судасны тогтолцооны өвчлөл, тэр дундаа цусны даралт ихсэх, зүрхний шигдээсийн өвчлөлөөр улсын дунджаас өндөр үзүүлэлттэй байгаа нь аяныг хэрэгжүүлэх нэг зорилтот шалтгаан болсон. 2018 оны байдлаар ховд аймгийн хэмжээнд өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд амьсгалын тогтолцооны өвчлөл нэгдүгээрт, зүрх судасны тогтолцооны өвчлөл хоёрдугаарт бичигдэж буй юм. Зүрх судасны өвчлөлийн 63,9 хувийг цусны даралт ихсэлт, 16,1 хувийг зүрхний судас бөглөрөлт, 7,3 хувийг тархи судасны өвчин тус тус эзэлж байна.

2018 оны Эрүүл мэндийн статистик мэдээллээр Монголын хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаанд амьсгалын зам, хоол боловсруулах, зүрх судас, шээс бэлгийн тогтолцооны өвчин болон бусад өвчин ноогдож байна. Цусны даралт өндөр байх нь бусад олон өвчний суурь болдгийг хүмүүс тэр бүр мэддэггүй. Өөрөөр хэлбэл, энэ нь зүрхний дутагдалд орох, тархинд цус харвах, зүрхний шигдээс болох магадлал өндөр ажээ. Түүнчлэн энэ өвчин сүүлийн үед эрс залуужиж, хот суурин газрын төдийгүй орон нутгийн хүн амын дунд хурдтай тархаж буй нь хөдөлгөөний хомсдол, хүн амын дундах таргалалт, зохисгүй хооллолт, амьдралын хэв маяг өөрчлөгдсөн, стресс зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж буй тухай эмч мэргэжилтнүүд хэлж байна.

Дэлхий даяар жил бүрийн 6-р сарын 14-нд “Дэлхийн Цусны Донорын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлдэг. Энэхүү өдрийн хүрээнд олон нийтийн аюулгүй цус цусан бүтээгдэхүүний талаарх мэдлэг, хандлагыг дээшлүүлэх, сайн дураараа авлагагүйгээр цусаа бэлэглэж, бусдын амь насыг аврах буянтай үйлст нэгдсэн цусны донорууддаа талархах зэрэг олон арга хэмжээ зохион байгууллаа. 2019 онд “Цусаа бэлэглэсэн донор тандаа баярлалаа” уриан дор Мөн энэ үеэр албан байгууллага иргэдийн дунд цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал, донор байхын нэр хүнд алдар, зохистой хэрэглээ сургалтыг эмч эмнэлгийн ажилчид эмч нарын дунд зохион байгуулж 160 гаруй иргэдийг хамрууллаа.

Антибиотик эмийн зохистой хэрэглээний талаар гарын авлага бэлтгэн нийт 60 үйлчлүүлэгч нарт тараан Антибиотик эмийг хэрхэн зохистой хэрэглэх бэ? Сэдвээр сургалт зохион байгуулсан. мөн антибиотик эмийн мэдлэг тодорхойлох зорилгоор асуумж авч дүгнэлт хийсэн.

- ❖ Цахим бүртгэлээр үйлчлүүлсэн нийт 130 иргэд
- ❖ Тасаг нэгжээр хэвтэн эмчлүүлж байгаа үйлчлүүлэгч -110
- ❖ Эмч-55
- ❖ Сувилагч-37
- ❖ Үйлчлэгч, ажилтан-45
- ❖ Khovd news.mn орон нутгийн мэдээллийн цахим хуудсанд мэдээлэл байршуулсан.
- ❖ Олон ястан телевизд видео хичээл болон сайтаас шторк татан авч 7 сарын 16 аас 26 хүртэл мэдээлэл цацсан. мөн олон ястан телевизд зочны цаг нэвтрүүлэгт эм зүйн албаны дарга оролцон Антибиотик эмийн зохистой хэрэглээ гэж юу бэ? сэдвээр ярилцлага хийж иргэд олон нийтэд мэдээлэл хийсэн.

БОЭТ-ийн цахимаар үйлчлүүлэж буй иргэдэд антибиотик эмийн зохистой хэрэглээ, эмийн гаж нөлөөний талаар видео хичээл 14 хоног гаргаж мэдээлэл өгсөн.

Эмч, сувилагч, үйлчлэгч ажилтан нарт антибиотик эмийн зохистой хэрэглээ болон тэсвэржилт үүсч буй талаар мэдээлэл өгснөөр антибиотик эмийн мэдлэг сайжирсан.

Эмч нарт MNS5376:2016 стандарт, зөрчлийн тухай хуулийн заалт, жорын судалгаа танилцуулснаар эмч нарын жор бичилт сайжирч антибиотик эмийг жорын маягтанд заавал бичдэг болж хандлага өөрчлөгдөж байна.

Эмийн сангууд антибиотик эмийг жорын маягтын дагуу заавал олгодог болж байна.ингэснээр ард иргэд эмч нарт хандан шаардлагатай антибиотик хэрэглэх заалтын дагуу хэрэглэх мөн замбраагүй хэрэглээ буурч байна.

БОЭТ-өөр үйлчлүүлсэн ард иргэд антибиотик эмийн зохистой хэрэглээний талаар мэдлэгтэй болж хандлага өөрчлөгдсөн

2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Ховд аймгийн БОЭТ-ийн Уламжлалт, сэргээн засах эмчилгээний тасгийн хамт олон “Уламжлалт анагаах ухаанаар эрүүл мэндээ хамгаалъя” сэдэвээр иргэд, үйлчлүүлэгчдэд зориулсан эрүүл мэндийн боловсрол олгох өдөрлөг зохион байгууллаа.

Энэхүү өдөрлөг нь Монголын улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд “Хүн амыг уламжлалт анагаах ухааны аргаар эрүүл мэндээ хамгаалах, мэдлэг, арга барилтай болгох, мэдээлэл, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх” зорилгын хүрээнд зохион байгуулсан бөгөөд өдөрлөгт 90 гаруй үйлчлүүлэгч оролцож , “Хий шар бадгана өвчний тухай”, “6 амтны тухай”, “Хүний биед улирал хэрхэн нөлөөлөх тухай”, “Хоолны үл зохицол”, “Идээ ундааны хэмжээг зохицуулах” сэдвүүдээр эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохион байгуулж, 300 гаруй ширхэг гарын авлага, зөвлөмж бэлтгэн тарааж танилцууллаа.

Дэлхийн сэтгэцийн өдрийг угтаж амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх амиа аврах “40 секундын үйлдэл” урианд нэгдэж Өсвөр насны хүүхдүүдийн амиа хорлолт сэдвээр сургуулийн эмч нар нийгмийн ажилтанууап сургалт хийлээ. Мөн Ховд олон ястаны телевизд ярилцлага өнч мэдээ мэдээлэл сэрэмжлүүлэг хийсэн.